

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Өлзийсүрэн	Дугаар	L210
Оршин суугаа аймаг	Увс аймаг	Оршин суугаа сум	Өмнөговь сумын Улиастай баг
Төрсөн газар	Өмнөговь сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Шар цөхийн хийд	Сүм хийдийн дугаар	УВӨГ 004
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 2	Ярилцлага авсан хүн	Билэг-Өрнөх



Увс аймгийн Өмнөговь сумын Шар цөхийн хийд, Дамбийжанцан лам

Билэг-Өрнөх: За өнөөдөр 2007 оны 6 сарын 2-ны өдөр.Увс аймгийн Өмнөговь сумын Улиастай багийн иргэн Өлзийсүрэнтэй уулзаж байна аа.

Өлзийсүрэн: Аа би энэ 2004 оноос эхлэн энэ Мөнжүүлийн Шарцөхийн хийдийн дурсгал, эд зүйлсийг ер нь цуглуулж эхэлсэн. Шарцөхийн хийд нь 1938 онд 300 гаруй лам байсан. Тэр тарж байгаа гэж тэгж ярьдаг. Мөн тэрнээс ч олон хүн байсан. Тэгээд цаг үеийн шаардлагаар залуу хүмүүс нь хар болж ингэж цөөрсөн гэж ярьдаг юм байна лээ. Аа энэ хийдийг бол Улаангомын хийдээс салбарлуулан 1700-аад оны сүүл орчмоос одоо байгуулсан. Энэ хийдийг тэр одоо Дамбийжанцан лам бас ирж өргөжүүлсэн , оролцсон гэж ярьдаг. Дамбийжанцан лам ирэхдээ нэг тэмээ ачаатай, нэг тэмээ унасан ирсэн , ингээд нутгийн хүмүүс бол тэр үедээ хоёр тэмээтэй ирсэн лам гэж ингэж ярьж байсан. Тэр хүн 1911 оны үед л ирсэн. Тэгээд 1970-аад он хүртэл түүний сүүлчийн хатан болох Шаваа эмгэн нь энд , энэ нутагт байж байсан. Тэгээд хотоос хүмүүс ирж тэр хүнтэй уулзахад та сүүлчийн амьд гэрч, тэр хүний тухай та ярьж өг өө гэж ингэсэн.Тэгэхэд тэр үед аа хөөрхий минь сайн л хүн байсан юм даа, одоо тэгээд юу ярих вэй ингэсхийгээд нэг их юм яриагүй өнгөрч байсныг одоо манайхны

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

улсууд бүгд мэднэ, нутгийн улсууд. Аа тэгээд жаа ламыг миний хувьд дүгнэж бодоход бол тухайн үедээ их бүтээн байгуулагч их тийм санаачилгатай хүн байжээ л гэж би боддог юм. Одоо ер нь сүүлийн үед цагийн юугаар ч гэсэн хүмүүс одоо ер нь юм хийж байсан хүн байна аа гэж ингэж ярьдаг л юм байна лээ.

Билэг-Өрнөх: За баярлалаа.